

ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, Хүн Амын Сургалт Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр “Монголын Хүн Амын Сэтгүүл”-ийн 16 дахь дугаарыг Дэлхийн хүн амын өдөрт зориулан бэлтгэж, эрхэм уншигч та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн “*Судалгаа*” хэсгээс Монгол хүний хөдөлмөр эрхэлж чадах насны дээд, доод хязгаарыг тогтоох судалгаа, түүний онолын үндэслэл, Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын ажлын өмнө тулгарч буй асуудлууд, тэдгээрийг шийдвэрлэх боломжит арга замуудыг тодорхойлох, Мэргэжлийн өвчний өнөөгийн байдал, цаашдын төлөв Монгол улсын ядуурлын төлөв байдал, Монголд авилгыг хориглоход анхаарах зарим асуудлууд, Монгол орны баруун бүсийн хүн ам зүйн орчны судалгаа зэрэг хүн амын хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөр эрхлэгчдийн эрүүл мэнд, бүс нутгийн хүн ам зүйн төлөв байдал, ядуурал болон авилгалын асуудлыг хөндсөн сонирхолтой судалгаануудтай танилцах болно.

Энэ удаагийнхаа тусгай буланг Дэлхийн хүн амын өдөрт зориулагдан бэлтгэв. НҮБ-ын Хүн амын сангаас бэлтгэсэн гаргасан “Дэлхийн хүн амын байдал 2007: Хотжилтын нөөц бололцоог ашиглах нь” тайлан илтгэлийн хураангуй болон “Эхийн эрүүл мэндийг хамгаалахад эрчүүдийн туслалцаа, дэмжлэг чухал” гэсэн өгүүллийг уншигч танд толилуулж байна.

Сэтгүүлийн “*Сургалт*” хэсгээс хамгийн бага квадратын аргаар шугаман хамаарлын тооцоолол хийхэд LINEST функцийг хэрэглэх, болон нийгмийн даатгалын үүсэл хөгжил, онцлогийн талаар сонирхолтой материалуудтай танилцаарай.

Харин “*Үзэл бодол*” хэсэгт өгүүлсэн баялгийн талаарх нийгмийн үнэлэмжийн стандарт бий болгон, түүнийг хүний хөгжлийн гол шалгуур үзүүлэлт болгох шаардлагатай байгаа талаар судлаачийн бичсэн санал бодлыг уншиж, Та өөрийн эргэцүүлгийг өрнүүлэх боломжтой юм.

Сэтгүүлийнхээ *English* хэсэгт нэг хүнд ногдох өдрийн орлого нэг доллараас доогуур, ядуурлын түвшинд аж төрж байгаа Монгол улсын хүн амын үнэлгээ, Монгол улсын хүн амын нас хүйсийн бүтцийг ашиглан 1956-2000 оны хүн амын тооллогын мэдээлэлд үнэлгээ хийсэн байдал, Монгол дахь дотоод шилжих хөдөлгөөнийг Зелинскийн онолоор тайлбарласан байдлыг танилцуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт нийтлэгдэж буй судалгаа, шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар уншигч та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг өрнүүлэн, манай дараагийн дугаарт өөрийн материалыа ирүүлнэ гэдэгт бид итгэлтэй байна.

Эцэст нь, Монгол улсын хүн ам, хөгжлийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюун ухаан, мэдлэг чадвараа зориулж буй нийт эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн, оюутан, залуучууд та бүхэндээ болон сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлж байгаа НҮБ-ын Хүн Амын Сангийн Суурин Төлөөлөгчийн Газарт сэтгүүлийн редакцийн нэрийн өмнөөс гүн талархлаа илэрхийлье.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ